

**АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ,
УРЬДЧИЛАН ЭРГИЙЛЭХ АЖЛЫН 2014 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2014 оны 11 дүгээр сарын 14

Номгон

НЭГ. АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

- Аймгийн Засаг даргын 2014 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 84 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан Авлигын эсрэг үйл ажиллагааны 2013 оны тайланг хэлэлцэх, аймгийн хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд хяналт тавих, тайлагнах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.



Ахлагчаар: Хууль зүйн хэлтэсийн дарга С.Баярмаа

Сум дундын 3 дугаар шүүхийн шүүгч Л.Нарангэрэл

Цагдаагийн газрын дэд дарга Ч.Мөнхбаатар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дэд дарга Д.Үнэнбат

Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн Б.Цэрэнлхагва

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн А.Цэцэнбилэг

Амьд хууль ТББ-ийн тэргүүн Н.Энхжаргал

Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Х.Оюунтамир нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, 2014 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 100 дугаар захирамжаар Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг батламжлуулан ажиллаа. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд ИНБ-ын саналыг авах хэлэлцүүлэг зохион байгуулж, *bayankhongor.gov.mn* сайтад байршуулан иргэдээс санал авч мөн төрийн байгууллагуудын санал, Авлигатай тэмцэх газраас санал авсаны үндсэн дээр Мерси кор олон улсын байгууллага, “Амьд хууль” ТББ-тай хамтран боловсруулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2014 оны 03-р сарын 17-ны өдрийн 8/2 тоот тогтоолоор тусгайлан 18 550 000 төгрөгийг батлуулан авилгын эсрэг соён гэгээрүүлэх ажилд зориулан төсөвлөсөн. /Хавсралтаас үзэх/



ХОЁР. АВИЛГААС АНГИД БАЙХ УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга, засаг даргыгн тамгын газрын дарга, бодлогын хэлтэсийн дарга нар төрийн байгууллагын нийт албан хаагчидад авлигыг тэвчих, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг өдөр тутмын үйл ажиллагаа, хэрэгцээ болгон ажиллах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлээ илэрхийлж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэж ажиллахыг үндсэн зорилтоо болгож ажиллахыг зөвлөсөн. Мөн Аймгийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 331 дугаар захирамжийн дагуу “Авлигаас ангид байгууллага” гэдгийг иргэдэд илэрхийлж нийт төрийн байгууллагуудын байранд “Та авилгагүй бүсэд нэвтэрлээ” санамжийг нийтэд харагдахуйцаар байршуулах, “Авлигаас ангиад байх амлалтын дэвтэр”-т нийт төрийн албан хаагч нарын баталгааг гаргуулж ажиллахаар нийт төрийн байгууллага, албан хаагчдад

уриалсан.



Тус захирамжийн дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын үүдэнд харагдахуйцаар санамжийг байрлуулж, агентлагуудын дарга нарын шуурхай мэдээллийн цагаар “Авлигаас ангид байх амлалтын дэвтэр”-т аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Хууль зүйн хэлтсийн дарга, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нар баталгаа гарган гарын үсгээр баталгаажуулан авлигатай тэмцэх хүчин чармайлт гаргаж, авлига, ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлж, авлигын эсрэг нэгэн зорилготой ажиллахаа амласан болно.



Уг захирамжийг биелэлтийг хяналт шинжилгээ-үнэлгээтэй хамтатган агентлагуудаар явж шалган санамж, амлалтын дэвтэрийг хийгээгүй байгууллагад хариуцлагатай ажиллахыг сануулсан. Агентлагын дарга нар болон сумын засаг дарга

нартай байгуулсан үр дүнгийн гэрээд хувь хүний манлайлал, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахыг тусгайлан заалт болгон оруулсан. “Амьд хууль-төв” ТББ-тай хамтран 2 удаагийн телевизийн ярилцлага болон нэвтэрүүлгийг бэлтгэж мөн сургалт зохион байгуулсан. /DVD-г хавсаргав/

ГУРАВ.НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХОЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ БАТАЛЖ МӨРДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

“Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм”-ийг боловсруулан төслийг Авлигтай тэмцэх газарт хүргүүлэн хянуулж, холбогдох саналыг тусган иргэдээс bayankhongor.gov.mn сайтаад дамжуулан санал авч, төрийн байгууллагад ёс зүйн дүрмэнд хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд өргөн барьсан хэдий ч одоогоор батлагдаагүй. 2014 оны 12-р сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

ДӨРӨВ. АВИЛГААС, АШИГ СОНИРХОЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

“Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг угтаж аймгийн хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор **“Авлигын эсрэг хамтдаа”** аяныг 2014 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулав.

Аяны хүрээнд аймгийн “Хуульч эмэгтэйчүүдийн холбоо”, “Амьд хууль-төв” ТББ-тай хамтран ерөнхий боловсролын сургуулийн багш ахлах ангийн сургагчид, болон цэцэрлэгийн багш, МСҮТ, ХҮДС-ийн багш, оюутануудад “Авлигын эсрэг хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар сургалт, хэлэлцүүлэгийг зохион байгуулав. Мөн аяны хүрээнд засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагын эрх бүхий албан тушаалтнууд албан хаагчиддаа сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.


Сургалтад давхардсан тоогоор 280 гаруй багш ажилчид, оюутнууд оролцож, “Авлигын эсрэг хууль” “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг

зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар бэлтгэсэн 2000 ширхэг гарын авлага тараасан.

Мөн аяны хүрээнд 20 сум, агентлагууд “АХА” тэмцээн болон “Бүтээлч ажил”-ыг “Авлигын эсрэг хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хүрээнд бэлтгэн зохион байгуулж шалгарсан нэг шилдэг оролцогч пиналын шатанд оролцож тэргүүн байранд Боловсролын газрын мэргэжилтэн Л.Оюунбилэг, дэд байранд Баянцагаан сумын цэцэрлэгийн багш Ц.Өлзийсайхан шалгарлаа.



“Бүтээлч ажил”-ын хүрээнд “Авлигын эсрэг хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар тодорхой ажлыг зохион байгуулсан. Тухайлбал:





“Авлигын эсрэг хамтдаа” аяны хүрээнд авлигын 4 төрлийн шторкийг орон нутгийн телевизүүд болон төв талбайн дэлгэцээр давтамжтайгаар иргэдэд хүргэж байна.


Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн гарын авлага сурталчилгааны ажлыг сумдад болон байгууллагуудад хувиран олшруулж хүртээмжтэй байдлаар хүргүүлэн ажиллаа. “Төлөөс” жүжгийг орон нутгийн 3 телевизээр 9 удаагийн давталттайгаар цацаж DVD г олшруулан 20 сумын засаг даргын тамгын газар, гэмт хэргээс урьчдиглан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлж сум багуудад ажиллах үеэрээ багийн иргэдэд үзүүлсэн.

Авилгын эсрэг хуульд орсон нэмэлт, ХАСХОМ болон ХАСУМэдүүлэг, холбогдох бусад мэдээ, мэдээлэлийг байгууллага бүр самбартаа байршуулж хэвшсэн.


2014 оны байдлаар авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаал үйлчилгээний талаарх 6 асуулга бүхий судалгааг нийт 20 сумын 1640 иргэнээс авахад




3. Төрийн байгууллагад авилга ямар түвшинд байна вэ?




4. Та төрийн үйлчилгээ авахда төрийн албан хаагчдад авилга өгч байсан уу?



5. Таны бодлоор аль түвшний албан тушаалтан авилгад хамгийн их өртөх магадлалтай вэ?



Худалдан авах ажиллагааны алба Авилгад хамгийн их өртөх магадлалтай байгууллагыг нэрлэнэ үү?



Энэхүү судалгаанаас дүгнэхэд эрүүл мэндийн газар, хууль шүүхийн байгууллага хамгийн их авилгад өртөх магадлалтай бөгөөд удирдах албан тушаалтнууд авилга авах магадлал өндөр байгаа нь цаашид авилгын эсрэг соён гэгээрүүлэх ажилд байгууллагын удирдлагыг татан оролцуулах арга хэмжээг зохион байгуулах идвэхжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Мөн мэдээлэлийн ил тод байдлыг хангах тал дээр дорвитой ажил арга хэмжээг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байна. Судалгааны дүнгээс харахад төрийн албан хаагчид авилга өгсөн гэх хүний тоо 18%-тай байгаа тул энэ тоог бууруулах тал дээр мөн авилгад өртөх магадлал өндөр ажил, албан тушаалтнуудад чиглэсэн зорилтот арга хэмжээг зохион байгуулах нь шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ.

ТАВ.БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Аймгийн Худалдан авах ажиллагааны албанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, тендерийн урилга, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын талаарх мэдээлэл, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан түүнтэй танилцах боломжоор хангах талаар Худалдан авах ажиллагааны алба нь худалдан авах ажиллагааны зар, оролцсон аж ахуйн нэгж, шалгаруулалтын талаарх бүх мэдээ мэдээллийг www.Bayankhongor.gov.mn, www.e-procurement.mn, www.meps.gov.mn сайтад байршуулан, тендерийн урилгыг ардчилал сонинд нийтлүүлж, мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж байна.

Баянхонгор аймгийн 2013 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тухай тайланг “Өнөөгийн Баянхонгор” 10 хоног тутмын сонины 2014 оны 01 дүгээр сарын эхний №01, 02 дугаарт бүрэн эхээр нийтлэн , 2014 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг “Bayankhongor.gov.mn” сайтад байршуулан 2-р сарын 14-нд болсон аймгийн “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-д оролцсон 200 гаруй иргэдэд хувиалан танилцууллаа.

2014 оны 02 дугаар сарын 21-ны өдөр “Шилэн тендер-2014” уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулав. Тус зөвлөгөөнд бизнес эрхлэгч компани , хоршоо , нөхөрлөл , төсөвт байгууллагууд , жижиг худалдаа эрхлэгчдийн төлөөлөл зэрэг 400 гаруй хүн оролцлоо.

Зөвлөгөөнд оролцогчдод Худалдан авах ажиллагааны албаны 2013 оны ажлын гүйцэтгэл , 2014 оны төлөвлөгөөг танилцууллаа. Мөн Баянхонгор сумын 2013 оны худалдан авах ажиллагааны тайлан , 2014 оны төлөвлөгөөг Засаг даргын тамгын газрын дарга Ш.Хүрэлбаатар танилцуулав.



ШИЛЭН ТЕНДЕР-2014



Үнэлгээний хороог тендер зарлах бүр байгуулдаг. Үнэлгээний хорооны гишүүдээс Улсын их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05-р тогтоолын 4-р хавсралтаар батлагдсан “ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-г 2014 оны 07-р сарас хойш /өмнөх мэдэгдэлийг нөхөн авч/ гаргаж meduuleg.iaas.mn сайтын программд оруулан ажиллаж байна.

Баянхонгор аймгийн бүх төсөвт албан газруудын 10 саяас доош төгрөгийн худалдан авалтыг иргэдэд мэдээлж жижиг худалдаа эрхэлдэг иргэд аж ахуйн нэгжүүд дээрх байгууллагуудын худалдан авалтанд оролцох боломж байгааг мэдээллээ.

Төсөвт байгууллагууд аль болох бизнест оролцохгүй худалдан авах ажиллагаанд иргэд аж ахуйн нэгжүүдийг оролцуулах боломжийг хангах бодлого баримтлаж байгааг зарлалаа.

Худалдан авах ажиллагааны алба нь дотоод үйл ажиллагаа, төсөв, санхүү, тендерийн урилга бусад холбогдох мэдээллийг өөрийн мэдээллийн самбар , Засгийн газрын худалдан авах ажиллагааны “e-procurement.mn”, Баянхонгор аймгийн албан ёсны “bayankhongor.gov.mn” сайт, “Ардчилал” “Үндэсний шуудан” “Өнөөгийн Баянхонгор” зэрэг сонинууд зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллээ хүргэсээр байна.

ЗУРГАА. ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Хуулийг хэрэгжүүлж зөрчлийг арилгаж ажиллахтай холбогдуулан 2014 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 6/1030, “Зөрчил арилгах тухай”, аймгийн Засаг даргын 2014 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 1а/886, “Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай ”, мөн 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 1а/790 “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 2014 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 6/981 дугаар албан бичгээр бүх сумын Засаг дарга, төсөвт байгууллагын дарга нарт хүргүүлэн биелэлтийг гаргаж ажиллаж байна.

Нийтийн албанд томилогдохдоо хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй зөрчилтэй томилгоо хийсэн 18 сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нарт үүрэг болгон зөрчил арилгах талаар хугацаатай албан бичиг хүргүүлж, аймгийн Засаг даргын захирамж болон тамгын газрын даргын тушаалаар томилогдог хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй 40 албан тушаалтныг ажлаас түр чөлөөлж, зөрчлийг арилган авлигатай тэмцэх газрын 2014 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 05/9103, 03/9015 дугаар албан бичгийн дагуу эгүүлэн томилсон. Авлигатай тэмцэх газраас 2014 оны 01/8286 дугаар албан бичиг ирүүлсний дагуу аймгийн Түүх, угсаатны зүйн музейн захирал Д.Маахүүд аймгийн Засаг даргын 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 595 дугаар захирамжаар “албан тушаалын цалингийн хэмжээг нэг сарын хугацаагаар 30 хувиар бууруулах” сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг авсан.

Төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бүтэц зохион байгуулалтыг өөрчлөлт хийх тухай Аймгийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 335 дугаар захирамж гарч хавсралтаар Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжигддэг байгууллагууд болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарыг сэлгэн ажиллуулах журам батламжлуулан ажиллаж байна.

ДОЛОО.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Аймгийн хэмжээний төрийн байгууллагууд Төсвийн хууль, Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын дагуу Төсвийн ил тод байдлын самбар ажиллуулж хэвшсэн.

Мөн цахим хуудсанд тухайн жилийн төсөв, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн орлог бүрдүүлэлт-ийн талаарх мэдээллийг цахим хуудас www.bayankhongor.gov.mn сайтад тухай бүр байршуулж байна

Байгууллага бүр өөрийн салбарт мөрдөгддөг хүчин төгөлдөр дүрэм, журмыг мэдээлэлийн самбартаа байршуулж, төрийн албан хаагч нэг бүр өдөр тутам ьухайн салбартаа хэрэглэгдэх дүрэм журмын жагсаалт гарган үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тухайн цаг үед шаардлагатай хууль тогтоомж болон маягт, түүнийг бөглөх зааврыг мэдээлэлийн самбартаа тухай бүр байршуулдаг. Жишээ нь: ХАСХОМ, өргөдөл гомдол шийдвэрлэх журам, захирамж, гэрээ хянуулах журам гэх мэт...

2013 он 11 дүгээр сарын 15-ны өдрөөс хойш аймгийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гараагүй бөгөөд аймгийн багийн Засаг дарга нар, төрийн албан хаагчдад нэгдсэн сургалтад хийж “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр” гаргах аргачлалыг захирамжийн төсөл /загвар/-аар өгсөн.

2013 оны 11 дүгээр сарын 15-наас хойш Хууль зүйн яамнаас боловсруулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг төсөл, “Нотариатын тухай хууль”-ийн төсөл, “Захиргааны ерөнхий хууль”-ийн төсөл, Согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төсөл /Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга/-ын төслийн үзэл баримтлал, танилцуулгын талаарх хэлэлцүүлгийг 3 үе шаттай зохион байгуулж 2014 оны 04 сарын 30-наас 05 дугаар сарын 02-ны өдрүүдэд төрийн байгууллагуудын албан хаагчид болон иргэд, согтууруулах ундаа

худалдаалдаг болон түүгээр үйлчилдэг аж ахуй нэгж, дэлгүүрийн эздийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.


Мөн “Зөв-Баянхонгор” архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих хөтөлбөрийг боловсруулж холбогдох агентлаг болон 20 сумдаас санал авч аймгийн 9 багийн иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан.



20 сум болон агентлагуудын мэдээллийн самбар болон сайтад байршуулсан мэдээ мэдээллийг шалгаж дутуу, хангалтгүй байгаа байгууллага, сумдад хугацаа өгч хууль хэрэгжүүлж ажиллахыг тухай бүр зөвлөж ажилласан.

Аймгийн засаг даргын тамгын газар болон засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагууд, 20 сумын тамгын газар албан хаагчдын өрөөний үүд, компьютер, принтер зэрэг өөрийн болон бусдын нүдэнд ил үзэгдэх газарт “Авлигагүй орчин” “Авлига таны үгүй чухал” “би авлига авахгүй” санамжийг байршуулсан.





- Эрх бүхий албан тушаалтнуудын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусган зохих нэмэгдэлийг олгон ажиллаж байна.

20 сум, агентлагуудад нийтийн албан хаагчийн ёс зүйг дотоод журамд тусгаж ажиллах талаар чиглэл өгч ажилласан.

Аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг Аймгийн Засаг даргын захирамжаар олгодог. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагаа чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг www.bayankhongor.gov.mn сайтад байршуулж байгаа.

Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжуудыг www.Bayankhongor.gov.mn сайтад тухай байршуулан ажиллаж байна.

-Төрийн байгууллагуудын ажилтнуудын хариуцсан үйл ажиллагааны чиг үүргийг олон нийтэд ил тод мэдээлэх зорилгоор мэдээллийн самбар ажиллуулж, аймгийн нэгдсэн www.Bayankhongor.gov.mn сайтыг тогтмол үйл ажиллагаатай болгосон.

НАЙМ.БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙГ ТӨЛӨВЛӨГДСӨН ЗАРДАЛД ҮР АШИГТАЙ ЗАРЦУУЛАХ

Аймгийн хэмжээний төрийн байгууллагууд Төсвийн хууль, Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын дагуу Төсвийн ил тод байдлын самбар ажиллуулж хэвшсэн.

Мөн цахим хуудсанд тухайн жилийн төсөв, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн орлог бүрдүүлэлт-ийн талаарх мэдээллийг цахим хуудас www.bayankhongor.gov.mn сайтад тухай бүр байршуулж байна

Концессийн зүйлийн жагсаалт, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт одоогоор байхгүй байгаа болно.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 8/3 дугаар тогтоолоор концессийн зүйлийн жагсаалтийг батласан одоогоор нэмэлт өөрчлөлт ороогүй.



ЕС.АВИЛГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, ЭНЭ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛИЙГ ИРГЭД, БАЙГУУЛЛАГА ЧӨЛӨӨТӨЙ АВАХ НӨХЦӨЛИЙГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ил тод байдлыг хангаж үр ашгийг сайжруулах нь” сэдэвт уулзалт семинарын үеэр 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүний хэрэгжилт, үнэлгээний талаар мэдээлэл хийж “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” болон “Авлигын эсрэг хууль”-ийн үйлчлэлд хамаарах этгээдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, мэдээллийн системийг ашиглан гаргах мөн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу мэдээллийг ил тод байлгах, иргэдийг мэдээлэл авах эрхээр хангах зэрэг сургалтыг хийв. Уг семинарт 20 сумын засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, засаг

даргын тамгын газрын дарга нар оролцсон. Мөн Аймгийн хэмжээний авлигын эсрэг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд үндэслэн сум, байгууллага бүр авилгын эсрэг соён гэгээрүүлэх, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллах чиглэл өгсөн. 20 сумын засаг даргын тамгын газрын дарга нар болон засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нийт 30 эрх бүхий албан тушаалтанд 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.



Хууль зүйн хэлтэс төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх, төрийн хууль тогтоомж сурталчлах чиг үүрэг бүхий “Сургагч-багш” бэлтгэх 8 цагийн хууль, эрх зүйн сургалтыг 6 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулаж сургалтад 20 сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх хэрэгжүүлэгч агентлагуудаас тус бүр нэг ажилтан, нийт 30 төрийн албан хаагч оролцож хууль, эрх зүйн мэдлэг, хууль тогтоомжийг сурталчилан таниулах чадавхиа дээшлүүлж, хууль, эрх зүйн ном, гарын авлагаар хангагдаж, аймгийн Засаг даргын баталгаажуулсан “Сургагч-багш”-ийн “ГЭРЧИЛГЭЭ”-г гардан авлаа. Тус сургалтаар “Амьд хууль-төв” ТББ-ын тэргүүн Н.Энхжаргал “Авлигын эсрэг хууль”-иар 2 цагийн сургалтыг хийв.



Мөн Аймгийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны ажлын төлөвлөгөө”-ний дагуу сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, Төрийн сангийн төлөөлөгч, нягтлан бодогч нарт “Авлигын мөн чанар”, “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” сэдвээр 1 цагийн сургалт, мэдээлэл хийв. 20 сумын сургуулийн захирал, цэцэрлэгийн

эрхлэгч, архив, бичиг хэргийн ажилтнуудад “Авлигын мөн чанар, авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр 2 цагийн сургалт хийж, гарын авлага тараасан. Мөн тамгын гзарын мэдээллийн ажилтан сумдын тамгын газрын дарга, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудад мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу мэдээллийг цахим хуудсанд хэрхэн байршуулах талаар нэг өдрийн сургалтыг зохион байгуулав.

Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаар иргэдэд лавлагаа, мэдээлэл өгөх, санал асуулга, судалгаа явуулах, иргэдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэх, аймаг, орон нутгаа хөгжүүлэх чиглэлээр гарч байгаа шийдвэрт иргэдийнхээ санал бодлыг тусгах, иргэндээ шуурхай үйлчлэх зорилготойгоор байгуулагдсан.

“Иргэд хүлээн авах төв”-нь иргэдийн санал хүсэл гомдол, өргөдлийг

- Иргэдээ сонсох 70440001, 70440002 дугаар утсаар шууд
- www.bayankhongor.gov.mn www.sanal.bkh.gov.mn цахим хуудсаар
- Sanal@bayankhongor.gov.mn цахим шуудангийн хаягаар тус тус хүлээн авдаг.

Тус төвд аймгийн ИТХ-ын дарга долоо хоног бүрийн мягмар гарагт, Засаг дарга Пүрэв гарагт, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга лхавга гаригт хэлтсийн дарга нар даваа болон баасан гарагуудад иргэдийг хүлээн авч үүлзаж байна.

Авилгын эсрэг 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Мерси кор ОУБ, “Амьд хууль” ТББ, Хуульч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран ажилласан.

АРАВ.ТӨРИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2014 онд 477 аж ахуй нэгжид 506 удаагийн шалгалтыг хийлээ. Үүнээс төлөвлөгөөт 3933, төлөвлөгөөт бус 41, зөвлөн туслах үйлчилгээ 72 байна. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын үр дүн илэрсэн зөрчлийн талаар bkh.inspection.gov.mn сайт болон өөрийн мэдээлэлийн самбарт байршуулан ил тод болгож ажиллаж байна. /тайланг хавсралтаас үзэх/

Аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын алба нь 2014 оны төлөвлөгөөгөөр 18 аж ахуйн үйл ажиллагаанд аудит хийхээс 16 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд аудит хийж 12,0 сая төгрөгийн зөрчил илэрүүлж 62 заалт бүхий 14 зөвлөмж гаргасны 92,0 хувийг хэрэгжүүлж, эрсдлээс урьдчлан сэргийлж ажиллажээ.

Аймгийн засаг даргын 2 удаагийн захирамж, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 122 дугаартай тогтоолоор нөхөн сэргээлтийн гэрээ хийсэн аж ахуйн

нэгжүүдэд хяналт тавих ажлын хэсэг байгуулаган нөхөн сэргээлтийн гэрээ хийгдсэн 12 компанийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж зөрчил гаргасан аж ахуй нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авч ажиллаа. Мөн Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Баянхонгор сумын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй нийтийн хоол, бар, рестарон, караоке барны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлыг хэсэг, эмийн бөөний болон жижиглэн худалдааны төвийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг тус тус байгуулан ажилласан. Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч С.Баярмаа нь 2014 оны 05-р сарын 28-ны өдөр “Модерн экспо” үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд шалгалт хийж үйл ажиллагааг нь зогсоож энэ талаар аймгийн албан ёсны сайт болон орон нутгийн 3 телевизээр иргэдэд мэдээлсэн. Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын баталсан 2014 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 1/34 тоот удирдамжийн дагуу Баянхонгор аймаг дахь “Монос фарм трейд” ХХК-ийн эмийн сангуудын үйл ажиллагаа нь Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийлээ.

АРВАННЭГ.ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ОЛОН НИЙТИЙГ ТҮҮНТЭЙ ТАНИЛЦАХ БОЛОМЖООР ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Аймгийн хэмжээнд төрийн албаны мэргэшлийн шалгалт 4 удаа зарлагдаж байгаа бөгөөд төрийн албаны төв зөвлөлийн сайт болох www.csc.gov.mn, аймгийн цахим хуудас www.bayankhongor.gov.mn, аймгийн facebook групп, Өнөөгийн Баянхонгор сонин, төв замын урсдаг зарлалын самбараар тус тус мэдээлдэг.

Туслах болон дэс түшмэлийн ангилалын төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоог нөхөх иргэдийг сонгон шалгаруулах төрийн албаны мэргэшлийн шалгалтын тухай гэсэн нэртэйгээр 2014 оны 2 дугаар сар, 5 дугаар сар, 6 дугаар сар, 9 дүгээр саруудад тус зарлсан.

Мөн удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 3 удаа зарлаж байгаа бөгөөд 1 дүгээр сар, 4 дүгээр сар, 10 дугаар саруудад тус тус зарласан.

АРВАН ХОЁР. АЛБАН ХААГЧ БҮРИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРИЙГ ТОДОРХОЙ БОЛГОХ

Төрийн албан хаагч нэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн тогтоолын дагуу ажлын хэсэг гарган боловсруулсан. 2013 онд аймгийн засаг дарга, засаг даргын тамгын газрын дарга, хууль зүйн хэлтэсийн даргын өгсөн 6 удаагийн зөвлөмжийн дагуу Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, тамхины хяналтын тухай

хуулийн холбогдох заалтыг оруулж хууль сурталчлах ажлыг эзэнжүүлэн зааж өгсөн болно.

Төрийн албан хаагчийн хариуцсан ажил, чиг үүргийг тодорхой болгож мэдээлэлийн самбарт болон bayankhongor.gov.mn сайтад байршуулсан.

БУСАД АЖИЛ

Аймгийн хэмжээний төрийн байгууллагууд Төсвийн хууль, Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын дагуу Төсвийн ил тод байдлын самбар ажиллуулж хэвшсэн.



Төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдэгээс бусад аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдол аймгийн хэмжээнд байхгүй.

Аймгийн тамгын газар нь хууль тогтоомжоор олгогдсон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тодорхой хэмжээний дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг видео тайлангаар 20 сумын 104 багийн давхардсан тоогоор 15 000 орчим иргэнд хүргэж тайлан танилцуулах үеэр төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд газар дээр хүргэх, 2015 оны бодлогын бичиг баримтад санал авах, хууль сурталчлах, брошур танилцуулга тарааж /авилгын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах ашиг сонтрхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, хоршооны тухай, нийгмийн даатгалын тухай, нийгмийн халамжийн тухай, газрын тухай, мэдээлэлийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудаар давхардсан тоогоор 20 000



Дээрх ажлуудтай холбоотой баримтуудыг хавсралтаар хүргүүлэв

Хавсралт хавтас ширхэг CD, ширхэг плаш.

ТАЙЛАН БИЧСЭН

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН

Д.ОТГОНТӨГС

ХЯНАСАН

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

С.БАЯРМАА